Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Гэвч энэ нь Шинжлэх ухаан технологийн салбарын хэмжээнд хийгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгаа бөгөөд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлого журам боловсруулан мөрдөх шаардлагатай байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамны Хяналт шинжилгээ дотоод аудитын газраас хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 5 асуудлаар зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 799,690.4 мянган төгрөгөөс тооцон 7,996.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,422,473.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,224.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 262,144.0 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, засгийн газрын оролцоо, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	40,692.8	18,471.9	(22,220.9)
УРЬДЧИЛГАА	639,892.5	640,969.5	(1,077.0)
БАРАА МАТЕРИАЛ	472,714.9	385,125.4	(87,589.5)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,735,825.0	8,582,414.4	(153,410.6)
НИЙТ ХӨРӨНГӨ	9,889,125.2	9,626,981.2	(262,144.0)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	155,656.5	279,290.1	(123,633.6)
Засгийн газрын хувь оролцоо	9,733,468.7	9,347,691.1	(385,777.6)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨМЧИЙН ДҮН	9,889,125.2	9,626,981.2	(262,144.0)

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 18,471.9 мянган төгрөг болж 22,220.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд авлагыг барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 640,969.5 мянган төгрөг болж 1,077.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгаарлах өрөө гаргаж, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, цэвэрлэгээний бодис авсан зэрэг нь үлдэгдэл нэмэгдэх шалтгаан болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,582,414.4 мянган төгрөг болж 153,410.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалсан шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,749,307.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,749,307.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,749,307.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, гурван арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,749,307.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,749,307.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,749,307.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,728,964.5 мянган төгрөгийг зарцуулж, 20,343.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа хоцроосон 42 мэдээлэл байгаа боловч оруулсан мэдээлэл үнэн зөв байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд 9,239.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 24,026.0 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 33,265.4 мянган төгрөгийн 7 зөвлөмжийн хэрэгжилт 94.0 хувьтай ба хэрэгжүүлээгүй 1,965.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжид албан шаардлага өгөв.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	9,239.4	2	9,239.4	-	-	-
Албан шаардлага	5	24,026.0	4	22,061.0	1	1,965.0	5.9
Зөвлөмж	7	33,265.4	6	31,300.4	1	1,965.0	5.9
НИЙТ ДҮН	14	66,530.8	12	62,600.8	2	3,930.0	5.9

/мянган төгрөг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,475,017.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,333,668.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,544.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 45,195.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 94,608.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Оны эцсийн 780,092.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байсныг аудитын явцад баталгаажуулж ирүүлсэн;
2. Бараа материалын дансанд 637.4 мянган төгрөгийн 2 ш Зам заагч JPS-ыг бүртгэснийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж бүртгэсэн;
3. 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад орсон 1,499.9 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгөнд 1,124.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүйг нэмж байгуулсан;
4. Тайлант хугацаанд 169 ажилтны 1,412,711.1 мянган төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлснөөс суутгасан 98,742.3 мянган төгрөгийг татварын байгууллагад тайлагнаагүй байсныг хувь хүний орлогын албан татварын тайланд нөхөж тайлагнасан;
5. Хэрэгжиж дууссан, ШУТС-ийн итгэмжлэн хадгалагчид актаар хүлээлгэн өгсөн 139,103.0 мянган төгрөгийн төсөв бүхий 3 төслийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж ирснийг тайлант хугацааны зардлаар бүртгэж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,544.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 45,195.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Унаа хоолны нөхөн олговрыг 1,544.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 –д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 3-ын 12(б)4 –ын хянамгай байх заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох

2. Албан томилолтын хуудасгүй 28,068.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлтгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1 –д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 3-ын 12 (б) 4–ийн хянамгай байх заалттай нийцэхгүй, хэмжилт ба үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Автомашины замын хуудасгүй 17,127.9 мянган төгрөгийн шатахууны зардал олгож, тооцоог бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлтгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 3 –ын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 173 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулалгүй дараа сард нь байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" гэж заасныг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 94,608.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хэмжээнд хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөрүүдийг, шинжлэх ухаан технологийн сангийн итгэмжлэгдсэн хадгалагчид хүлээлгэн өгсөн акттай тулган шалгах;

Мөн дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын, орон нутаг дахь нэгжүүдийн үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад ирүүлсэн эргэлтийн болон үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооллогын бүртгэлтэй тулгахад салбар нэгжүүд дэх мал амьтдыг тооллогын бүртгэлд тусгаагүй, авлага өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна. Иймд орон нутаг дахь нэгжүүдийн бүртгэл тайлагналыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан дахь авлага, өр төлбөрийн дүн дэлгэрэнгүй бүртгэлээс 34,983.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20.2.5-д "Дансны өглөг,авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй байна.

4.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг,авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.2 Балансын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 59,625.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн

баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасныг

4.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага болон өр төлбөрийг дутуу бүртгэсэн байх,

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дүгээр заалтуудыг мөрдөж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3-т “Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, толилуулга ба тодруулга, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Төслийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэрэгжихгүй байх.

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг мөрдөж ажиллаж, төсөл тус бүрд дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төсөл тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж ажиллана.

4.4.1 Илрүүлэлт:

Дорнод, Архангай, Говийн, Төв аймгийн Батсүмбэр сум дахь нэгжүүд нь мэргэжлийн нягтлан бодогчгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл:

Хөрөнгө завших, мэдээ, тайлан үнэн зөв тайлагнагдахгүй байх.

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, орон нутаг дахь салбар, нэгжүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.23	Аудитын нэр: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ҮАГ-2021/88/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Санхүүгийн тайлан дахь 25,778.4 мянган төгрөгийн өглөгийн оны эцсийн үлдэгдэл нь өглөгийн журналын дүнгээс 25,456.4 мянган төгрөгөөр дутуу, авлагын журналын оны эцсийн 789,017.6 мянган төгрөгийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 9,526.8 мянган төгрөгөөр дутуу байна.	34,983.3	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Т.Батсүх Г.Өсөхжаргал
2	Томилолтын хуудасгүй, мөнгөн урьдчилгааны тайлангүй нийт 21 удаагийн 28,068.0 мянган төгрөгийн замын зардлыг олгож, мөнгөн урьдчилгааны тайлан гаргуулахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.	28,068.0	Албан шаардлага	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
3	Албан томилолтын шатахууны зардалд нийт 17,127.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч замын хуудасгүй, шатахууны тооцоог бодоогүй байна.	17,127.9	Албан шаардлага	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
4	Цалин хөлсний давтан тооцоолол хийхэд нэр бүхий удаагийн 1,544.8 мянган төгрөгийг унааны нөхөн олговрыг илүү олгосон байна..	1,544.8	Төлбөрийн акт тогтоох	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
5	Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 59,625.2 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэсэн байна.	59,625.3	Зөвлөмж өгөх	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
6	Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, төслүүдтэй холбоотой зардлыг 34600 код бүхий урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэхдээ төсөл тус бүрээр задалж, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал

7	Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 173 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулалгүй дараа сард нь байршуулсан байна.	-	Албан шаардлага	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
8	Дорнод, Архангай, Говийн ,Төв аймгийн Батсүмбэр сум дахь нэгжүүд мэргэжлийн нягтлан бодогчгүй, нягтлан бодох бүртгэлийг энгийн бүртгэлээр хөтөлсөн, салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал	Т.Батсүх Г.Өсөхжаргал
НИЙТ ДҮН		141,349.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 156/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/ББ/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 173 мэдээллээс хугацаа хоцроосон 42 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ИХМОНГОЛ
ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 42/A0160058

Улаанбаатар хот

САГ-2021/88/СТА-ТМБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нь 1,544,800.00 (нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн унаа, хоолны нөхөн олговрыг илүү тооцож олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 1,544,800.00 (нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн унаа, хоолны нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ИМ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

[Signature]



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 157/АД/60058

Улаанбаатар хот

САГ-2021/88/СТА-ТМБ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автомашины замын хуудасгүй, шатахууны тооцоог бодохгүйгээр нэр бүхий 10 хүнд 17,127,909.50 (арван долоон сая нэг зуун хорин долоон мянга есөн зуун есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн шатахууны зардлыг олгосон байна.

Энэ нь санхүүгийн тайлагналын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөн зарцуулж, дээрх алдаа зөрчлийг арилган, биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ИХМОНГОЛ
ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 155/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/28/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтын хуудас, мөнгөн урьдчилгааны тайлангүйгээр нэр бүхий 35 хүнд 28,068,000.00 (хорин найман сая жаран найман мянган) төгрөгийн замын зардлыг олгосон байна.

Энэ нь Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5-т "эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөн зарцуулж, дээрх алдаа зөрчлийг арилган, биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Т.Батсүх, ерөнхий нягтлан бодогч Г.Өсөхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ИХМОНГОЛ
ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Г.АРИУНБАТ

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.